

**“БАСАРХАН” ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАХИРГАА, ЭЦЭГ ЭХ /АСРАН ХАМГААЛАГЧ/-ИЙН
ХООРОНД БАЙГУУЛАХ ГЭРЭЭ**

2022 оны –р сарын-ны өдөр

№.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсэн байгуулагдсан, Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Их тойруу 28 тоот хаягт оршин байдаг “Басархан” цэцэрлэг (цаашид “Цэцэрлэг” гэх), түүнийг төлөөлж цэцэрлэгийн эрхлэгч Жамбалжамц овогтой Наран, нөгөө талаас цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны зохион байгуулалт, дотоод дүрэм, журам, төлбөрийн нөхцөлийг хүлээн зөвшөөрчбүлгийн суралцагч овогтой (цаашид “Суралцагч” гэх)-ийн эцэг, эх, асран хамгаалагч (доогуур нь зурах) овогтой РД: (цаашид “Эцэг, эх, асран хамгаалагч” гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Боловсролын тухай хууль, Цэцэрлэгийн хүүхэд хамгаалалын бодлого болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль болон Эцэг эхийн мөрдөх дотоод журамд нийцүүлэн харилцан тохирч, дор дурдсан нөхцлүүдээр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ”) байгуулж байна.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Цэцэрлэг болон эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хоорондын харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Цэцэрлэгийн үйл ажиллагаа нь цэцэрлэг, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагаан дээр тулгуурлан явагдана.
- 1.3 Цэцэрлэг болон эцэг эх, асран хамгаалагч нь холбогдох хууль, дүрэм, журмыг сахих, хүүхдэд ээлтэй байх, тэгш хандах, харилцан хүндэтгэлтэй хандах болон сургалтын тогтвортой, тасралтгүй байх зарчмыг баримтална.
- 1.4 Цэцэрлэгийн дотоод дүрэм, журам, нэмэлт гэрээ болон хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд талууд хүндэтгэн үзэж биелүүлнэ.

Хоёр. Цэцэрлэгийн эрх, үүрэг

2.1. Цэцэрлэг дараах үүргийг хүлээнэ:

- 2.1.1 Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;
- 2.1.2 Хүүхдийн аюулгүй байдал, ариун цэвэр, сэтгэл зүйн таатай нөхцөлийг хангасан сургалтын орчин бүрдүүлэх;
- 2.1.3 Эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаагаа явуулах;
- 2.1.4 Мэргэжлийн багшлах боловсон хүчнээр хангах;
- 2.1.5 Эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангасан тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, ном, шаардлагатай техник хэрэгсэлээр хангах;
- 2.1.6 Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн хөгжлийн талаар зөвлөгөө өгч, хамтран ажиллах;

- 2.1.7 Эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд бэлтгэсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй технологиор боловсруулагдсан, хүүхдийн өдрийн илчлэг, нормод тохирсон хоол хүнсээр хангах;
- 2.1.8 Сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулна;

2.2. Цэцэрлэг дараах эрхтэй:

- 2.2.1 Эцэг эхэд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн хөгжил, хүмүүжлийн асуудлаар зөвлөгөө өгөх, ярилцах;
- 2.2.2 Цэцэрлэгийн дотоод журмыг танилцуулж, мөрдөхийг шаардах;
- 2.2.3 Гэрээний дагуу үүргээ биелүүлэхийг шаардах;

Гурав. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг

3.1. Эцэг эх дараахи үүргийг хүлээнэ:

- 3.1.1 Цэцэрлэгийн эцэг эхэд зориулсан дотоод журмыг мөрдөх;
- 3.1.2 Цэцэрлэгээс зохиогдож буй хүүхдийн сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд оролцох;
- 3.1.3 Хүүхдээ цэцэрлэгийн сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд хичээлийн жилийн турш бүрэн хамруулах (9.20 минутаас өмнө хүүхдээ цэцэрлэгт хүргэн ирэх);
- 3.1.4 Хүүхдийг ханиад хүрсэн эхний халдвартай 3 хоногт нь цэцэрлэгт нь ирүүлэхгүй байх, халдварт өвчин туссан тохиолдолд бүлгийн багш, эмчид цаг алдалгүй заавал мэдэгдэх;
- 3.1.5 Цэцэрлэгээс хүүхдийг авах хүмүүсийн нэр, утсыг тодорхой бичиж өгөх ба нэр нь дурдагдаагүй хүнээр буюу насанд хүрээгүй хүүхдээр авахуулахгүй байх. Шаардлагатай тохиолдолд заавал багшид урьдчилан мэдэгдэх;
- 3.1.6 Цэцэрлэгийн сургалт, хөгжлийн ажлыг жигд явуулах нөхцөлийг хангах үүднээс сургалтын төлбөрийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөх;

3.2 Эцэг эх нь дараахи эрхийг эдэлнэ:

- 3.2.1 Цэцэрлэгээс гэрээнд заасны дагуу үүргээ биелүүлэхийг шаардах;
- 3.2.2 Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, боловсролын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа авах;
- 3.2.3 Цэцэрлэгийн үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавьж, бүлгийн багш, арга зүйч, Цэцэрлэгийн зөвлөл, цэцэрлэгийн захиргаанд амаар болон бичгээр санал, гомдол тавих;
- 3.2.4 Хүүхдийг сургах үйл ажиллагаатай холбогдуулан өөрөөс гаргасан зардал, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;
- 3.2.5 Цэцэрлэгийг хөгжүүлэх үзэл баримтлал, хөтөлбөр, дүрэм журам боловсруулах, шийдвэр гаргахад оролцох;
- 3.2.6 Цэцэрлэгийн хүмүүжил, сургалтын үйл ажиллагаатай танилцах, урьдчилан тохиролцсоны дагуу үйл ажиллагаанд биечлэн оролцох;
- 3.2.7 Хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнс, хүнсний хангамжийн талаар мэдээлэл авах, санал солилцох;

Дөрөв. Төлбөр тооцооны асуудлууд

- 4.1 Жил бүрийн 7-р сард “Басархан” цэцэрлэгийн Цэцэрлэгийн зөвлөлийн ээлжит хурлаар ирэх хичээлийн жилийн сургалтын төлбөр болон бусад үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоож батална.
- 4.2 Цэцэрлэгийн 2022-2023 оны хичээлийн жилийн нэг сарын төлбөр төгрөг байна.
- 4.3 Та хүүхдээ бүртгүүлэхдээ 9 дүгээр сарын төлбөрөө 100%, 1 дүгээр сарын төлбөрийн 50%-ийг урьдчилан хийнэ. Энэ нь таны хүүхэд бүтэн хичээлийн жил суралцана гэсэн баталгаа болно. /Жич: Та хүүхдээ цэцэрлэгээс сарын дундуур гаргах ба чөлөө авах хүсэлт тавьсан тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүйг анхаарна уу/
- 4.4 Эцэг эх асран хамгаалагчийн хүсэлтээр төлбөрийг сар, жилээр төлөх боломжтой ба төлбөрийн хуваарийг санхүүгийн албатай харилцан тохиролцож болно. /Хавсралт1/
- 4.5 Төлбөрийг дараах нэр бүхий банкны дансанд хийнэ. Гүйлгээний утга хэсэгт суралцагчийн овгийн эхний үсэг, нэр, анги, хэддүгээр сарын төлбөр зэргийг тодорхой бичиж шилжүүлнэ. /хавсралт 1/
- 4.6 Эцэг эх, асран хамгаалагч нь энэхүү гэрээний 4.4 дэх заалтын хавсралт 1-д заасан төлбөрийн хуваарийн дагуу төлбөр төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд гүйцэтгээгүй үнийн дүнгээс хэтэрсэн хоног тутамд 0,5 хувийн алданги тооцно.
- 4.7 Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан цэцэрлэг үйл ажиллагаа явуулаагүй үед тухайн сарын төлбөрийг буцаахгүй болно (Үүнд: байгалын гамшиг, төр захиргааны байгууллагаас шалтгаалсан түр зогсолт, нийгмийн гоц халдварын үед хөл хориг тогтоосон үе)
 - 4.7.1 Гамшиг, аюулт үзэгдлийн улмаас төрийн эрх бүхий байгууллагаас онц байдал зарлаж гамшиг, онц байдлын үеийн хорио цээрийн дэглэм тогтоож цэцэрлэгийн үйл ажиллагааг түр болон тодорхойгүй хугацаагаар зогсоосон тохиолдолд хорио цээр тогтоож танхимын сургалт үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон хугацааны сургалтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.
 - 4.7.2 4.7.1-д заасан нөхцөлд бүх хүүхэд цахим сургалтад хамрагдана. Цахим сургалтад хамрагдаагүй тохиолдолд гэрээ цуцалж, хүлээлгийн жагсаалт дахь дараагийн хүүхдийг элсүүлнэ.
 - 4.7.3 Цахим сургалтын сарын төлбөр нь 300.000 төгрөг байна.
 - 4.7.4 УОК болон холбогдох байгууллагуудын шийдвэрээр бүх нийтээр болон хэсэгчлэн хөл хорио тогтоогдсон үед цэцэрлэг цахим сургалтад шилжин төлбөрийг 4.7.3 дахь заалтын дагуу шийдвэрлэнэ.
- 4.8 Хүүхэд өвчлөх, гадаад оронд зорчих, сургуулийн амралт болон бусад шалтгаанаар чөлөө авсан үед төлбөр буцаагдахгүй мөн дараа сарын төлбөр лүү шилжихгүй ба зайлшгүй шаардлагатай тохиолдолд цэцэрлэгт явсан хоногийн төлбөрийг өдрийн төлбөрөөр тооцно.
- 4.9 Нэг өдрийн тооцох төлбөр 35,000 төгрөг (гучин таван мянган төгрөг) байна.
- 4.10 Тарах цагаас оройтож авсан тохиолдолд 15 минут тутамд 2500 төгрөгийг багшид төлнө.

Тав. Гэрээ цуцлах

- 5.1. Хүүхэд цэцэрлэгээс гарч байгаагаар албан ёсоор мэдэгдсэн өдрөөс эхлэн гэрээг цуцалсанд тооцно.
- 5.2. Дараах тохиолдолд цэцэрлэг өөрийн санаачилгаар Гэрээг цуцлана. Үүнд: цэцэрлэгийн дотоод журам болон Гэрээг удаа дараа зөрчсөн.
- 5.2.1. Сургалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй, өмнөх хичээлийн жилийн үлдэгдэлтэй, олон дахин шаардуулж, цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагаанд доголдол учруулсан;
- 5.2.2. Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтээр суралцагчийг шилжүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд;

Зургаа. Бусад

- 6.1. Цэцэрлэг дээр, хүүхдийн дэргэд ёс суртахуунгүй асуудал гаргахгүйг хоёр талаас хичээн ажиллах ба цэцэрлэгийн зүгээс буруутай үйлдэл гарвал хохирлыг харилцан тохиролцож барагдуулна.
- 6.2. Гэрээ гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд нэг жилийн хугацаанд хүчинтэй байж тухайн хичээлийн жилийн эцэст гэрээ байгуулагч цэцэрлэгийн захиргаатай харилцан тохиролцсоны үндсэн дээр сунгана.
- 6.3. Энэхүү гэрээний нөхцөлийг биелүүлэх явцад гарсан ямар нэг маргаантай асуудлыг хоёр тал харилцан ойлголцох үндсэн дээр шийдвэрлэнэ. Хэрэв харилцан тохиролцохгүй бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.4. Гэрээг тус бүр хоёр хувь, монгол хэл дээр үйлдэх бөгөөд талууд тус бүр нэг нэг хувийг авч хадгална.

Энэхүү гэрээний нөхцөлийг зөвшөөрч гэрээ байгуулсан:

“А” талыг төлөөлж

“Басархан” цэцэрлэгийн
Арга зүйч /Д.Золзаяа/
Хаяг: ЧД-н 5-р хороо 28- байр Утас:
70119979
E mail: basarkhan2005@gmail.com
Web site: basarkhan.mn
Facebook: Басархан цэцэрлэг

“Б” талыг төлөөлж

Эцэг эх, асран хамгаалагчдийг бүрэн
төлөөлж буй
Овог:
Нэр:
Суралцагчын хэн болох:
..... /гарын үсэг/
Утасны дугаар:
Гэрийн хаяг:
.....
.....